

2008.02.28

Дугаар 27

“Жам зам” ХХК-д банк бус санхүүгийн үйл  
ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.1 дэх хэсэг, “Жам зам” ХХК-ийн үүсгэн байгуулагчдын хурлын 2007 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

Нэг.“Жам зам” ХХК-д Улаанбаатар хотод Банк бус санхүүгийн дараах төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.Үүнд:

- 1.Зээлийн;
- 2.Гадаад валютын арилжааны.

Хоёр.Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Жам зам” ХХК /Ч.Энхбат/-д үүрэг болгосугай.

Гурав.Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Ж.Жадамбаа/, “Жам зам” ХХК-ийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Банк бус санхүүгийн байгууллагын газар /Х.Бум-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ